

ТӨРИЙН БАНКНЫ 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. Банкны тухай
2. Онцлох ажлууд
3. Банкны дунд хугацааны зорилт
4. Дундаж давхаргыг дэмжигч банк болох зорилтын хүрээнд
 - Шинэ, онцлох бүтээгдэхүүн
 - Урамшуулалт аян, өдөрлөг, арга хэмжээ
5. Тогтвортой хөгжил
6. Нийгмийн хариуцлага

2. САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛ




□ **Алсын хараа:**
Дундаж давхаргыг дэмжигч, үндэсний тэргүүлэгч банк байна.

□ **Эрхэм зорилго:**
Харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, ил тод, сайн засаглалтай, дундаж давхаргыг дэмжих, бойжуулахад чиглэсэн санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэт технологи ашиглан хүртээмжтэй хүргэх тогтолцоог бүрдүүлнэ.

□ **Банкны удирдлага, зохион байгуулалт:**

- Системийн хэмжээнд 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 3,420 ажилтан ажиллаж байна.



□ **Банкны хувьцаа эзэмшигчид:**



2024 оны эхний хагас жилийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн тайлангаар Төрийн банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тоо 9,295 байна.

□ **Хувьцаа эзэмшигчдийн хурал:**

2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар “Төрийн банк” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталлаа.

□ **Банк ногдол ашиг хуваарилсан тухай:**

“Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 10 дугаар тогтоолын дагуу 2023 оны цэвэр ашгаас нийт 49.9 тэрбум төгрөгийн ногдол ашгийг 9,211 хувьцаа эзэмшигчдэд 2024 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК болон банкаар дамжуулан тараалаа.



31.5 сая ам.долларын эх үүсвэр татлаа

Банк хөдөө аж ахуйн салбарын зээлийн зориулалтаар Америкийн Нэгдсэн Улсын Каргилл Файнэншл Сервисес Интернэйшнл байгууллагаас хамтын ажиллагаагаа өргөжүүлэн нийт 31.5 сая ам.долларын эх үүсвэрийг татан төвлөрүүллээ.



“Хүний нөөцийн бодлого”-ыг шинэчлэн баталлаа

Банкны “Хүний нөөцийн бодлого”-ыг шинэчлэн баталлаа.

“Орон нутгийн нэмэгдэл”-ийг орон нутгийн нэгжийн ажилтнуудад ажиллаж буй бүсээс хамааран 5-30 хувиар олгож эхэллээ.



“Хоршооны гишүүн малчны зээл”-ийг олгож эхэллээ

2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 5,595 зээлдэгчийн 198.9 тэрбум төгрөгийн хоршооны гишүүн малчны зээлийг олгосон байна.



Малчны зээлийн хугацааг сунгалаа

Улсын хэмжээнд өвөлжилт, хаваржилтын нөхцөл хүндэрсэнтэй холбоотой 57,069 зээлийн дансанд 674.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй малчны зээлийн хугацааг 12 сараар сунгаж, Үүнээс 48,879 зээлийн дансанд 599.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй Малчин иргэнд олгосон зээлийн 2024 онд харилцагчаас төлөх зээлийн хүүг 6 хувь болгон өөрчилсөн.

Төрийн банк 2024 онд БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ-ний хүрээнд стратегийн тэргүүлэх 3 чиглэлийн дагуу зорилтууд дэвшүүлэн ажилласан.

- **II. Дундаж давхаргыг дэмжихэд чиглэсэн санхүүгийн боловсрол, зөвлөгөө, мэдээлэл хүргэх, бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, цахим шилжилт хийх**

- **I. Зах зээлээ тэлж, санхүүгийн үзүүлэлтүүдийг зорилтот түвшинд хүргэх**



- **III. Банкны үйл ажиллагааг байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, зохистой засаглалыг бэхжүүлэх чиглэлд хандуулах, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах**

Санхүүгийн үйлчилгээ үзүүлэх



+20,816 Иргэн **103.3** тэрбум төгрөгийн хуримтлал үүсгэлээ.



+83,702 Зээлдэгчид **2,308** тэрбум төгрөгийн зээл олголоо.



+2,589 өрхийг орон сууцтай болголоо.

- ОСИЗ – 1,923
- Орон сууцны зээл – 611
- Эрчим хүчний хэмнэлттэй амины ОС зээл - 55



+4,624 Ажлын байрыг хадгаллаа.

Нийт **104,518** иргэн

Бүтээгдэхүүн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх



+86 Киоскоор **391,648** иргэнд үйлчилгээ үзүүллээ.



+541 ПОС нэмэгдэж, нийт **9,572** боллоо.



+53,855 иргэн шинээр бүртгүүлж **728,917** харилцагч Гялсбанк ашиглаж байна.



+75,375 Иргэн карт шинээр ашиглаж байна.



Даатгалын зуучлал **+43,528** гэрээг байгууллаа.

Нийт гүйлгээний **87%** цахимаар хийгддэг боллоо.

Нийт **564,406** иргэн

Санхүүгийн боловсрол, зөвлөгөө мэдээлэл хүргэх



“БРЭНД РЕКЛАМ” **2.2 сая** иргэнд мэдээлэл хүргэлээ

2 аймаг, **2** дүүрэгт “Харилцагчийн өдөрлөг”



+4 Цуврал контент

ЖДБ-ийг оролцуулсан “Амжилтын түүх” 4 цуврал контент - сошиал сувгаар **34.8 мянган** хүнд



+5,958 Бизнес эрхлэгч

Инкубатор төвийн харилцагч болж Санхүүгийн боловсрол олгосон.

+56,603 Оюутан, сурагч


Нийт **2,297,361** иргэн

Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгсөн.

ШИНЭ, ОНЦЛОХ БҮТЭЭГДЭХҮҮН



Монгол Улсад 90 хүртэлх хоногийн хугацаатай ирсэн жуулчдад татварын буцаан олголт олгох **“TAX REFUND”** үйлчилгээг зах зээлд нэвтрүүллээ.



Гадаадад ажиллаж, амьдарч буй Төрийн банкны харилцагч **“Хаяс”** хугацаатай хадгаламжийг банкны вэб сайтад хандан онлайн-аар нээх боломжтой боллоо.



Зээлийн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж зээл олголтын шимтгэлийг **0.3%-1.0%** хүртэл хувиар уян хатан тогтоолоо.



“Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл”-ийн хэмжээг иргэнд 200.0 сая төгрөг хүртэл, хуулийн этгээдэд 500.0 сая төгрөг хүртэл болгон нэмэгдүүллээ.




Төрийн банкны “Эрүүл иргэн” хадгаламж, “Эрүүл иргэн” карттай харилцагч БНСУ-ын “Dearim Saint Mary’s” эмнэлэг болон “Medical Advice” эмнэлэг зуулчлалын байгууллагатай хамтран ажилладаг 70 эмнэлгээр **20 хүртэл хувийн хөнгөлөлттэй** үнээр үйлчлүүлэх боломжтой боллоо.

УРАМШУУЛАЛТ АЯН, ӨДӨРЛӨГ, АРГА ХЭМЖЭЭ



“Парис 2024 зуны олимп-Ялалтыг ойроос дэмжье” виза картын урамшуулалт аяныг 2024.03.05-2024.05.31 хооронд зохион байгууллаа.



Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл зөвлөгөөг **102,500** харилцагчдад хүргэсэн.



Төрийн банк, Амины орон сууцны инновац хөгжлийн төвтэй хамтран “Тогтвортой хөгжил-Ногоон ирээдүй” үзэсгэлэн худалдааг амжилттай зохион байгууллаа.



“BARILGA EXPO 2024” Олон Улсын барилгын үзэсгэлэнд оролцож, ногоон зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан явуулын банкаар ажиллалаа.



Сар шинийн баярыг тохиолдуулан “Миний Монгол -2024” үзэсгэлэн худалдааг 2 дахь жилдээ амжилттай зохион байгуулж Улаанбаатар хот болон орон нутгийн 322 харилцагч, жижиг дунд бизнес эрхлэгч нарыг урьж оролцууллаа.

Тогтвортой санхүүжилт



**Ногоон
зээлийн
багц**

36.5

тэрбум төгрөг

42.0%

Өмнөх оноос өссөн

**Тогтвортой
хөгжилд
чиглэсэн зээл**

138.0

тэрбум төгрөг

49.5%

Өмнөх оноос өссөн

Хүлэмжийн хийн ялгаруулалт



**Хамрах хүрээ 1 болон 2
/Цэвэр ялгаруулалт/**

11,805

тонн CO2

2022 он

12,354

тонн CO2

2023 он

Тайлагнал



Монголын Хөрөнгийн биржид
2023 оны “Байгаль орчин,
нийгэм засаглалын тайлан”

WE SUPPORT



НҮБ-ын Даян дэлхийн гэрээнд
2023 онд оролцогч болсноор
анхны тайлан Явцын тайлан
/Communication on Progress/

Хамтын ажиллагаа, гишүүнчлэл



Монголын
Тогтвортой
Санхүүжилтийн
Холбоо



НҮБ-ын Даян
дэлхийн гэрээ



Нүүрстөрөгчийн
нягтлан бодох
бүртгэлийн
санхүүгийн
түншлэл



MUFG


Техникийн зөвлөх үйлчилгээ
авч “Банкны Тогтвортой
санхүүжилтийн хүрээ”-г
боловсруулж байна.

Сургалт



Academy

Жендерийн тэгш байдал, Бизнес ба хүний эрх,
Хүний эрхийн магадлан шинжилгээ Зохистой
хөдөлмөрийн сэдвээр нийт 15 модуль сургалт



“Эрчим хүчний хэмнэлтийн тухай” ойлголт,
мэдлэгийг дээшүүлүүлэх сургалт



Нүүрстөрөгчийн нягтлан бодох бүртгэлийн
санхүүгийн түншлэлийн санхүүжүүлсэн
ялгаруулалтыг тооцох сургалт



Хөгжлийн Бэрхшээлтэй Хүний Хөгжлийн Ерөнхий
Газар болон Санхүү Эдийн Засгийн Их
Сургуультай хамтарч Жижиг, дунд бизнес эрхлэгч
хөгжлийн бэрхшээлтэй иргэд, асран хамгаалагчдад
санхүүгийн боловсрол олгож, чадавхжуулах
сургалтыг зохион байгууллаа.

□ “ГЯЛС ЦЭВЭРЛЭГЭЭ-2023” АЯН

2024.05.18-ны өдөр Монгол орон даяар 21 аймгийн 330 сумд Төрийн банкны нийт ажилтнууд гялс цэвэрлэгээг эхлүүлсэн.

Аяны хүрээнд нийт 7,000 га талбайг цэвэрлэж, 800 тонн буюу нийт 425 орчим автомашин хог хаягдлыг цуглуулсан.



□ "МОДЫГ МОД(А) БОЛГОЁ-АЖИЛТАН БҮР НЭГ МОД" АЯН

Тэрбум мод үндэсний хөтөлбөрийг дэмжих зорилгоор Төрийн банкны ажилтнуудын төлөөлөл “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн”-нд бургас мод тарьлаа.



□ “МАЛЧДАДАА ТУСАЛЪЯ” АЯН

Нийгмийн хариуцлагын хүрээнд банкны 4000 гаруй ажилтнуудын дунд “Малчдадаа тусалъя” аяныг өрнүүлж малын нэмнээ болон мөнгөн тусламж болох 46,725,000 төгрөгийн эрхийн бичгийг Онцгой Байдлын Ерөнхий Газарт гардуулан өгөв.




□ ХҮҮХДИЙН БАЯР




Төв цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулагдсан “Kids Art Festival 2024” арга хэмжээнд хүүхэд багачуудад хүндэтгэл үзүүлэх, халамжлах, банкны нэр хүндийг өсгөх, банкны талаар эерэг хандлага, сэтгэгдэл төрүүлэх, санхүүгийн боловсрол олгох, хүүхдэд зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд сурталчлах зорилгоор оролцсон. “Kids Art Festival 2024” арга хэмжээний эхлэлийг хамтдаа тавьж, дүрслэх урлагаар дамжуулан бүтээлч иргэдийг бэлдэхэд үнэтэй хувь нэмэр оруулсанд Төрийн банк ХК-нд “Талархал” дурсгав.



Нийт актив, активын өгөөж (ROA)




Зээлийн багц, чанаргүй зээлийн хувь




- 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар банкны нийт активын хэмжээ 5,531.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 37 хувиар өсөж, нийт зээлийн багц 3,140.9 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 30.2 хувиар өссөн ба чанаргүй зээлийн хувийг 6.2 хувь болгон өмнөх оны мөн үеэс 3.1 нэгжээр бууруулсан байна.

Өөрийн хөрөнгө, өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)




Татварын дараах ашиг /алдагдал/




/Тэрбум төгрөгөөр/

- Банкны өөрийн хөрөнгө 569.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 14.4 хувиар өссөн ба татварын дараах ашиг өмнөх оны мөн үеэс 2.7 тэрбум төгрөгөөр өсөж 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 44.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа.

Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа үзүүлэлт



Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт



- Монголбанкны шалгуур үзүүлэлтийг тогтмол ханган ажилласан төдийгүй системийн бүлгийн дундажтай харьцуулсан үзүүлэлтүүд дунджаас дээгүүр үзүүлэлттэй байна.
- Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцааг тогтмол ханган ажиллахын зэрэгцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг байнга давуулан биелүүлж ажилласан.

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА